



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

Бор-Өндөр сум

2026 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/46

Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.8.1, 9.8.2, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2026 оны А/59 дүгээр тушаал, Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2026 оны А/27 дугаар Тушаал, Хэнтий аймгийн Засаг даргын 2026 оны А/150 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнээр баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Р.Цэндсүрэн

Нарийн бичгийн дарга

Э.Гуамарал

Гишүүд

И.Энхтуяа

У.Пүрэвсүрэн

Д.Мөнгөнтуяа

Ч.Саруулмөнх

Б.Мөнх-Оргил

Н.Отгонбилэг

Ц.Мөнхтунгалаг

Ц.Бат-Эрдэнэ

Ц.Төртүвшин

Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч

Хүйх 5 дугаар багийн зохион байгуулагч

Бор-Өндөр 1 дүгээр багийн Засаг дарга

Холбоо 2 дугаар багийн Засаг дарга

Бумбат 3 дугаар багийн Засаг дарга

Уурхайчин 4 дүгээр багийн Засаг дарга

Хүйх 5 дугаар багийн Засаг дарга

Өлгий 6 дугаар багийн Засаг дарга

Өлгий 6 дугаар багийн зохион байгуулагч

"Ноён зүлэг" ХХК МЭҮН-ний захирал, малын эмч

"ЭнТэЧи" ХХК МЭҮН-ний захирал, малын эмч

2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

3. Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэх, товлосон цагт үхэр сүргээ бүрэн хамруулахыг Багийн Засаг дарга (И.Энхтуяа, У.Пүрэвсүрэн, Д.Мөнгөнтуяа,

Ч.Саруулмөнх, Б.Мөнх-Оргил, Н.Отгонбилэг) нарт, урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган, зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Р.Цэндсүрэн)-д даалгасугай.

4.Дархлаажуулалтад хамруулах малын тоо, шаардагдах вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (З. Ууганжаргал)-д, гүйцэтгэлийг вакцинжуулалт дууссанаас хойш 7 хоногийн дотор танилцуулж, тарилгын материалыг дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Р.Цэндсүрэн) -д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ

Сумын Засаг даргын 2026 оны...03.....
дүгээр сарын 27-ны өдрийн
1/26-р захирамжийн 1...-р хавсралт

БОР-ӨНДӨР СУМ ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ДАРХЛААЖУУЛАЛТЫН ХУВААРЬ

№	МЭҮН-ийн нэр	Дархлаажуулах малын тоо		Шаардлагатай вакцин /тун/	Шаардлагатай вакцин		
		Үхэр	гахай	Нийт	литр	Хайрцаг	шил
1	'Эн Тэ Чи " ХХК	1400	0	1400	2.8	0	28
2	'Ноён зүлэгт" ХХК	2700	0	2700	5.4	0	54
Нийт		4100	0	4100	8.2		82